

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/109/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: sunjidmaae@audit.gov.mn Аудитор: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/031/НА-СТА-ТШЗ



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

АДДС. ОД.АН № 95

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ШАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Р.ОЮУНЧИМЭГ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шарга сумын засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс сумын аварга малчдад бэлэг дурсгал, сар шинийн баяр, тэмээчдийн баяр, нутгийн золголт арга хэмжээ, бусад тэмцээн, уралдаан арга хэмжээнд 34,941.2 мянган төгрөгийг зарцуулсан;
- ЭМТ-ийн ашиглалтгүй байгаа байрны халаалтын зардлыг төлж 27,693.3 мянган төгрөгийг төсвөөс үр ашиггүй зарцуулсан;

8225020240

- Ажиллагсад нэмэгдэл цалин, амралтын мөнгийг цалинтай давхардуулан 1,690.7 мянган төгрөгийг олгосон, Нийгмийн даатгалын тайланд цалинг 4,549.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Хөрөнгөд бүртгэлтэй 151,759.1 мянган төгрөгийн малыг оны эцэст малчидтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, хүлээн аваагүй 24,907.8 мянган төгрөгийн хөрөнгийг тооллогын бүртгэл, тайланд тусгасан;
- Түрээсийн гэрээ байгуулахдаа Аймгийн ИТХ-аас баталсан тарифыг мөрдөөгүй, 4,909.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан аваагүй, санхүүгийн тайланд хөрөнгө, авлагыг 33,873.6 мянган төгрөгөөр дутуу тусгасан;
- Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн сумын 100 жилийн ойн дэмжлэгийн 99,835.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хийсэн баяр наадмын талбайн засварын ажлын төсвийг мэргэшсэн төсөвчнөөр хийлгэсэн боловч зураг төсвийг магадлалаар оруулаагүй, мэргэжлийн байгууллагаар техникийн хяналт хийлгээгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 657.7 мянган төгрөг, сумын 100 жилийн ойн арга хэмжээний дэмжлэгт 100,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчдаас 30,997.3 мянган төгрөгийн тусламж дэмжлэг авч, 123,490.6 мянган төгрөгийг зарцуулж, 8,164.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, авлагаар бүртгэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаагчдаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 799,289.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөснөөс 726,091.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 73,198.2 мянган төгрөгийг дутуу авсан, өөрийн орлогоор 1,200.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 925.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үндсэн хөрөнгөнд сумын 100 жилийн ойн дэмжлэгийн эх үүсвэрээр 99,835.5 мянган төгрөгийн наадмын талбайн сайжруулалтыг бүртгэсэн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 24,907.8 мянган төгрөгийн, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон 287,910.5 мянган төгрөгийн, ойн хандиваар ирсэн 142,449.8 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Тайлант онд өглөг дансны үлдэгдэл 86,938.5 мянган төгрөг болж, 77,007.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн татаас санхүүжилтийн орлогоос шалтгаалж санхүүжилт 73,198.2 мянган төгрөгөөр дутуу авсан, өмнөх оны халаалтын өрийг барагдуулаагүйтэй холбоотой байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 хөтөлбөр, 5 зорилт, 162 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 4 арга хэмжээ хугацаа болоогүй, 99 арга хэмжээг бүрэн, 50 арга

хэмжээг 70.0 хувь, 5 арга хэмжээг 50.0 хувь, 4 арга хэмжээг 30.0 хувьтай хэрэгжүүлэн нийт дүнгээр 95.7 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г. ГҮНЖИДМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>148,002,448.00</b>	<b>185,696,617.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	242,200.00	8,406,669.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	8,164,469.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	242,200.00	242,200.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	147,760,248.00	177,289,948.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	8,493,583.00	8,388,583.00
35110	Тусгай зориулалттай материал	8,493,583.00	8,388,583.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,806,565.00	21,941,265.00
35410	Бичиг хэргийн материал	6,500.00	91,200.00
35420	Аж ахуйн материал	8,800,065.00	21,850,065.00
35600	Мал амьтад	130,460,100.00	146,960,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,660,140,302.91</b>	<b>9,969,580,280.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГЭ</b>	9,660,140,302.91	9,969,580,280.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,619,380,302.91	1,929,935,280.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,107,875,899.07	1,195,283,749.07
39202	Хуримтлагдсан элэгдэл	(223,380,311.66)	(291,023,228.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	133,012,000.00	113,022,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(82,838,322.18)	(84,792,655.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	162,319,559.00	207,358,159.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(74,965,804.22)	(119,342,727.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,156,992.00	67,146,892.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,888,739.01)	(10,465,546.72)
39209	Зам, гүүрийн байгууламж	87,399,696.00	87,399,696.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(27,452,468.54)	(34,175,522.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	787,463,427.00	1,192,819,558.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(264,321,624.55)	(393,295,093.33)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,040,760,000.00	8,039,644,999.96
39301	Програм хангамж	2,230,000.00	2,230,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,115,000.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,038,530,000.00	8,038,530,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>9,808,142,750.91</b>	<b>10,155,276,897.00</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9,931,020.00</b>	<b>86,938,510.23</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	9,931,020.00	86,938,510.23
<b>413</b>	<b>Өглөг</b>	9,931,020.00	86,938,510.23
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	46,856,787.23
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,931,020.00	37,188,217.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	2,893,506.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,893,506.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,798,211,730.91</b>	<b>10,068,338,386.77</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	9,798,211,730.91	10,068,338,386.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	274,846,668.74	274,846,668.74
51101	Өмч: - төрийн	274,846,668.74	274,846,668.74
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	9,473,430,497.24	9,743,557,153.10
51210	Өмнөх үеийн үр дүн	9,473,430,497.24	9,473,430,497.24
51220	Тайлант үеийн үр дүн	-	270,126,655.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	49,934,564.93	49,934,564.93
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>9,808,142,750.91</b>	<b>10,155,276,897.00</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>9,014,326,155.00</b>	<b>1,356,252,857.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,333,344,360.00</b>	<b>498,506,150.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>8,333,344,360.00</b>	<b>498,506,150.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,160,000.00	40,425,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,360,000.00	925,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,800,000.00	39,500,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,246,085,360.00	441,581,150.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	60,099,000.00	16,500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>680,981,795.00</b>	<b>857,746,707.88</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,850,000.00</b>	<b>-</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,850,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>78,647,895.00</b>	<b>131,655,034.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	490,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,157,895.00	130,997,307.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	657,727.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>597,366,100.00</b>	<b>726,091,673.88</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	597,123,900.00	726,091,673.88
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	242,200.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>878,248,891.03</b>	<b>1,086,126,202.02</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>872,095,928.06</b>	<b>1,061,126,804.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>342,446,290.30</b>	<b>536,348,756.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>216,214,562.45</b>	<b>353,254,454.79</b>
210101	Үндсэн цалин	101,054,365.85	151,969,738.18
210102	Нэмэгдэл	3,873,273.00	4,889,226.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,200,000.00	9,660,000.00
210104	Урамшуулал	12,104,089.00	16,575,338.00
210105	Гэрээт ажлын хөлс	39,017,753.25	55,195,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,074,653.25</b>	<b>38,328,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,735,800.00	4,216,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,188,600.00	2,108,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	547,200.00	2,108,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,471,500.00	8,433,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	113,411,100.09	84,023,153.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>3,994,545.59</b>	<b>6,612,220.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	109,266,554.50	77,410,933.00
210302	Түлш, халаалт	150,000.00	-
210303	Цэвэр, бохир ус	36,943,180.00	35,511,167.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,355,100.00</b>	<b>3,600,300.00</b>
210401	Бичиг хэрэг	30,414,020.00	27,734,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,655,060.00	2,183,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00	-
210404	Ном, хэвлэл	60,000.00	30,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,393,000.00	1,962,727.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,000.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	450,000.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>450,000.00</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,049,419.00	104,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>320,000.00</b>	<b>-</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,729,419.00	104,000.00
210604	Урсгал засвар	13,888,000.00	11,290,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,888,000.00</b>	<b>11,290,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	83,645,279.00	20,883,723.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>82,473,328.00</b>	<b>19,423,347.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	550,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	299,915.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	136,176.00	90,376.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		

**Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	520,000.00
210807	Газрын төлбөр	75,860.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>239,244,906.42</b>	<b>317,770,203.91</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,396,524.00	40,504,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	198,348,382.42	277,165,503.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,152,962.97</b>	<b>24,999,397.84</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,115,000.00</b>	<b>24,959,449.20</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	24,059,449.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,115,000.00	900,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,037,962.97</b>	<b>39,948.64</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,037,962.97	39,948.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>8,136,077,263.97</b>	<b>270,126,655.86</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,516,284.09</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	14,516,284.09	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-14,516,284.09</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>8,121,560,979.88</b>	<b>270,126,655.86</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

( төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>682491,795.00</b>	<b>858,671,707.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,510,000.00</b>	<b>925,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,510,000.00</b>	<b>925,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,510,000.00	925,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,510,000.00	925,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>677,621,795.00</b>	<b>857,746,707.88</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,250,000.00</b>	<b>-</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,850,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>82,007,895.00</b>	<b>131,655,034.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	490,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,757,895.00	130,997,307.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	657,727.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>598,973,900.00</b>	<b>726,091,673.88</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	598,973,900.00	726,091,673.88
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>677,808,795.00</b>	<b>753,147,376.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>677,808,795.00</b>	<b>753,147,376.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>671,098,632.03</b>	<b>719,983,510.04</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>342,410,290.69</b>	<b>489,491,969.74</b>
210101	Үндсэн цалин	216,178,562.84	306,397,667.56
210102	Нэмэгдэл	101,054,365.85	151,969,738.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,873,273.00	4,889,226.00
210104	Урамшуулал	9,200,000.00	9,660,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,104,089.00	16,575,338.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,017,753.25</b>	<b>55,195,800.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,074,653.25	38,328,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,735,800.00	4,216,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,188,600.00	2,108,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	547,200.00	2,108,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,471,500.00	8,433,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>103,480,005.09</b>	<b>55,683,968.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,994,545.59	5,530,232.30
210302	Түлш, халаалт	99,335,459.50	50,153,736.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,498,905.00</b>	<b>30,190,622.00</b>
210401	Бичиг хэрэг	2,711,600.00	3,685,000.00
210402	Тээвэр, шатахуун	30,490,245.00	24,013,782.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,655,060.00	2,183,840.00
210404	Ном, хэвлэл	30,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	115,500.00	108,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	496,500.00	200,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>800,000.00</b>	<b>-</b>

**Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	350,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,713,300.00</b>	<b>7,915,727.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	320,000.00	-
210604	Урсгал засвар	6,393,300.00	7,915,727.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,888,000.00</b>	<b>11,290,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	13,888,000.00	11,290,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>85,666,198.00</b>	<b>26,057,723.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,494,247.00	24,597,347.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	550,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	299,915.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,176.00	90,376.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	520,000.00
210807	Газрын төлбөр	75,860.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>43,624,180.00</b>	<b>44,157,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,124,180.00	44,057,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	100,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,710,162.97</b>	<b>33,163,866.84</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,430,000.00</b>	<b>24,959,449.20</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	24,059,449.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,430,000.00	900,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,280,162.97</b>	<b>8,204,417.64</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,280,162.97	39,948.64
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,164,469.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>4,683,000.00</b>	<b>105,524,331.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>4,683,000.00</b>	<b>105,524,331.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,683,000.00</b>	<b>105,524,331.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,683,000.00</b>	<b>105,524,331.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,683,000.00	105,524,331.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(4,683,000.00)</b>	<b>(105,524,331.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**


(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	274,846,668.7	49,934,564.9	1,351,869,517.4	1,676,650,751.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	274,846,668.7	49,934,564.9	1,351,869,517.4	1,676,650,751.0
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	8,121,560,979.9	8,121,560,979.9
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	274,846,668.7	49,934,564.9	9,473,430,497.2	9,798,211,730.9
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	274,846,668.7	49,934,564.9	9,473,430,497.2	9,798,211,730.9
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	274,846,668.7	49,934,564.9	9,473,430,497.2	9,798,211,730.9
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	270,126,655.9	270,126,655.9
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	274,846,668.7	49,934,564.9	9,743,557,153.1	10,068,338,386.8

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	800,489,900.00	726,976,725.24	73,513,174.76	90.82
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	800,489,900.00	726,976,725.24	73,513,174.76	90.82
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	775,387,900.00	702,017,276.04	73,370,623.96	90.54
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	516,830,300.00	489,491,969.74	27,338,330.26	94.71
210101	Үндсэн цалин	306,931,200.00	306,397,667.56	533,532.44	99.83



Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	161,885,700.00	151,969,738.18	9,915,961.82	93.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,960,000.00	4,889,226.00	8,070,774.00	37.73
210104	Урамшуулал	9,660,000.00	9,660,000.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	25,393,400.00	16,575,338.00	8,818,062.00	65.27
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,700,700.00</b>	<b>55,195,800.00</b>	<b>11,504,900.00</b>	<b>82.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	48,300,500.00	38,328,400.00	9,972,100.00	79.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,600,100.00	4,216,300.00	383,800.00	91.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,300,000.00	2,108,700.00	191,300.00	91.68
210204	Ажилгүйдлийн даатгал	2,300,000.00	2,108,700.00	191,300.00	91.68
210205	Эрүүл мэндийн даатгал	9,200,100.00	8,433,700.00	766,400.00	91.67
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>70,600,000.00</b>	<b>55,683,968.30</b>	<b>14,916,031.70</b>	<b>78.87</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,600,000.00	5,530,232.30	69,767.70	98.75
210302	Тулш, халаалт	64,800,000.00	50,153,736.00	14,646,264.00	77.40
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	-	200,000.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,990,100.00</b>	<b>25,392,440.00</b>	<b>1,597,660.00</b>	<b>94.08</b>
210401	Бичиг хэрэг	3,939,500.00	3,370,000.00	569,500.00	85.54
210402	Тээвэр, шатахуун	19,630,600.00	19,630,600.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,310,000.00	2,083,840.00	226,160.00	90.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	110,000.00	108,000.00	2,000.00	98.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	200,000.00	800,000.00	20.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,000,000.00</b>	<b>13,361,800.00</b>	<b>2,638,200.00</b>	<b>83.51</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,909,800.00	90,200.00	98.20
210602	Тавилга	1,000,000.00	-	1,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	8,452,000.00	1,548,000.00	84.52
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,052,000.00</b>	<b>11,290,000.00</b>	<b>5,762,000.00</b>	<b>66.21</b>
210702	Дотоод албан томилолт	17,052,000.00	11,290,000.00	5,762,000.00	66.21
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,169,100.00</b>	<b>14,653,598.00</b>	<b>7,515,502.00</b>	<b>66.10</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,899,100.00	13,193,222.00	6,705,878.00	66.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	550,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	315,000.00	300,000.00	15,000.00	95.24
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	90,376.00	59,624.00	60.25
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	105,000.00	-	105,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.00	520,000.00	130,000.00	80.00
210807	Газрын төлбөр	500,000.00	-	500,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39,045,700.00</b>	<b>36,947,700.00</b>	<b>2,098,000.00</b>	<b>94.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,545,700.00	36,847,700.00	1,698,000.00	95.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	100,000.00	400,000.00	20.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,102,000.00</b>	<b>24,959,449.20</b>	<b>142,550.80</b>	<b>99.43</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,102,000.00</b>	<b>24,959,449.20</b>	<b>142,550.80</b>	<b>99.43</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,102,000.00	24,059,449.20	42,550.80	99.82
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	900,000.00	100,000.00	90.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>800,489,900.00</b>	<b>726,976,725.24</b>	<b>73,513,174.76</b>	<b>90.82</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>799,289,900.00</b>	<b>726,976,725.24</b>	<b>73,238,174.76</b>	<b>90.84</b>
132001	Орон нутгийн төсвөөс	799,289,900.00	726,051,725.24	73,238,174.76	90.84
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,200,000.00</b>	<b>925,000.00</b>	<b>275,000.00</b>	<b>77.08</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,200,000.00	925,000.00	275,000.00	77.08
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23	21	2	-
620001	Удирдах ажилтан	7	7		
620002	Гүйцэтгэх ажилтан	11	9	2	
620003	Үйлчлэх ажилтан	2	2		
620004	Гэрээт ажилтан	3	3		

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 33,873.6 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

### • Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг санхүүгийн тайланд 709.1 мянган төгрөгөөр дутуу тусгасан.
- Хүч хүр сод ХХК-иас Сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд хандивласан 25,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй.
- Аймгийн ЗДТГ-аас Залуу гэр бүлийг дэмжих санхүүжилтээр ирсэн 8,164.5 мянган төгрөгийг Төрийн санд төвлөрүүлснийг тайланд авлагаар тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 350,253.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 350,253.6 мянган төгрөгийн 12 зөрчил<sup>2</sup> илэрч 4,657.7 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 94,001.3 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгуулах албан шаардлага, 251,594.6 мянган төгрөгийн 3 заалт зөвлөмж хүргүүлээ.

## Төлбөрийн акт

1. Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 2 ажилтанд 921.8 мянган төгрөгийг илүү олгосон, 1 ажилтанд 768.8 мянган төгрөгийн цалин олгоод суутган тооцоо хийгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй зочид буудлыг түрээсийн төлбөрийн орлогын 120.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; гэж заасантай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

3. Наадмын талбайн засварын ажлын Хос Гандирс ХХК-тай 99,835.5 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлж, санхүүжилтийг олгохдоо төсөвт тусгасан зураг төсвийн ажлын дүн 2,847.0 мянган төгрөгийг гүйцэтгэгчид илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын дансанд төлбөрийн акт тогтоов.

#### Албан шаардлага

Ирээдүй союшн ХХК-ны нийлүүлсэн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 24,907.8 мянган төгрөгийн нийтийн бие засах байгууламж нь тооллогын явцад байхгүй, хөрөнгө бодитоор ирээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна." Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг хүлээн аваагүй, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдад бэлэг дурсгал, сар шинийн баярт 9,125.0 мянган төгрөг, нутгийн золголт арга хэмжээнд 4,020.0 мянган төгрөг, тэмээчдийн баярт 3,992.0 мянган төгрөг, сумын 100 жилийн ойд гэрийн тохижилтод 1,904.0 мянган төгрөгийн, бусад тэмцээн уралдаан, арга хэмжээнд 12,900.2 мянган төгрөг, нийт 31,941.2 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Сумын ЭМТ-ийн баланст бүртгэлтэй хуучин эмнэлгийн барилгыг аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр засварласан ч ашиглаагүй халаалтад холбож, ашиглалтгүй байрны халаалтын зардлын өр 2023 онд 9,931.0 мянган төгрөг, 2024 онд 17,762.3 мянган төгрөг, нийт 27,693.3 мянган төгрөгийн өр тайланд үүссэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж заасантай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглалтгүй байгаа барилгыг үр ашигтай ашиглах талаар шийдвэрлэн, өр төлбөрийг төсөвт хүндрэл учруулахгүйгээр барагдуулан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд 4,909.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан аваагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Нийгмийн даатгалын хэлтэст жирэмсэн, амаржсаны амралттай 1 ажилтны цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр мэдээлэхээр байхад 6 сарын хугацаанд 82.5 мянган төгрөгөөр мэдээлж 3,465.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн, 2024 оны 1 дүгээр сард 2 ажилтны цалинг 1,084.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлж, тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", 32 дугаар зүйлийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэж заасантай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалд ажиллагсдын дутуу мэдээлсэн зөрчлийг арилгаж албан шаардлага хүргүүлсэн.

6. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 49,917.7 мянган төгрөгийн 1, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 37,511.8 мянган төгрөгийн 4 мэдээллийг мэдээлээгүй, байгууллагын хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, аудитлагдсан тайланг мэдээлээгүй, хуулийн хэрэгжилт 65.0 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэлт: Шилэн дансны цахим системд мэдээллийг цаг хугацаанд оруулах албан шаардлага хүргүүлсэн.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодогч бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

1. Байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй 146,960.1 мянган төгрөгийн малыг оны эцэст малчидтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, дансанд бүртгэлтэй 4,799.0 мянган төгрөгийн малыг нэр төрлөөр нь оруулаагүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн хөрөнгийг тооллого хийж байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн, нотлох баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлд авч, албан хаагчдад эд хөрөнгийн картаар эзэмшүүлэн, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллах

##### Илрүүлэлт:

2. Сумын буудлыг түрээслэгч иргэнтэй гэрээ байгуулахдаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан түрээсийн талбайн хэмжээтэй уялдуулж, тарифыг мөрдөөгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Буудлын түрээсийн гэрээг ааймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан түрээсийн талбайн хэмжээ, тарифтай уялдуулан хийж, хэрэгжилтийг хангуулж ажиллах

##### Илрүүлэлт:

**Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

3. Сумын 100 жилийн ойн дэмжлэгээс "Шарга сумын баяр наадмын талбайн засварын ажил"-ын 99,835.5 мянган төгрөгийн төсвийг мэргэшсэн төсөвчнөөр хийлгэсэн боловч зураг төсөв магадлалаар ороогүй, төсөв зохиогч хяналт хэрэгжүүлсэн материалгүй, төсөв дээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх зардлыг тусгаагүй, магадалшгүй ажлын зардлыг нийт төсвийн 2 хувиар тусгаагүй түүнд мэргэжлийн байгууллага хяналт тавиагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах". Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралт "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.8.16-т "Барилга байгууламж болон их засварын ажлын төсөвт өртөгт барилгын үнэ бүрдлийн дүрэмд тусгасны дагуу зохиогчийн хяналт, захиалагчийн хяналт, магадалшгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсөл, хайгуулын ажил, барилга байгууламжийн норм, нормативын зардлын шимтгэл гэх мэтээр зардлыг нэг бүрчлэн тооцно"; Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаалын хавсралт "Барилгын төсөв зохиох дүрэм" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлэе.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шарга сумын ЗДТГ	3	33,873.6	3	33,873.6			3	33,873.6				
Дүн	3	33,873.6	3	33,873.6			3	33,873.6				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Шарга сумын ЗДТГ	11	350,253.6	3	4,657.7	5	94,001.3	3	251,594.6	-	-		
Дүн	11	350,253.6	3	4,657.7	5	94,001.3	3	251,594.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

( мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шарга сумын ЗДТГ	1				1							
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Шарга сумын ЗДТГ												
Дүн												
-Нийт дүн	1	-			1							

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		

-----oOo-----